



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 0/38

Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх хэсэг, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж олон нийтэд мэдээлэх” сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын ажлын баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Х.Сувдмаа)-т үүрэг болгосугай.

3.Аудитын тайланг цахим хуудаст нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхийг мэдээлэл технологийн ажилтан (ахлах аудитор С.Санжаажав)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Батсүрэн)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш МӨНХБАЯР



4525010114

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**“АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ,
НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН
НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ 1. НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭ ХУУЛИАР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН, БОДИТОЙ ЭХ ҮҮСВЭРЭЭС БҮРДҮҮЛЖЭЭ.....	6
БҮЛЭГ 2. НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛЬД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БАРИМТАЛЖ, ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.	7
ДҮГНЭЛТ:	8

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МАН	Монгол Ардын нам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчдийн дансны мэдээлэл	5
Хүснэгт 2	Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр	6
Хүснэгт 3	Сонгуулийн зардлын гүйцэтгэл	7

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/44 дүгээр тушаал, “Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө” болон “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх ...” гэж заасныг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилго

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн санхүүжилт, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Энэ зорилгыг хангахын тулд дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж, гүйцэтгэв. Үүнд:

- Нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн санхүүжилтээ хуулиар хүлээн зөвшөөрсөн, бодитой эх үүсвэрээс бүрдүүлсэн эсэх
- Сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлаа зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, харилцагч банкны дансны хуулга, бусад шаардлагатай баримт материалыг хамруулан дүн шинжилгээ хийв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, АДБОУС 100-400, 4000, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг мөрдлөг болгосон.

Талуудын хүлээх үүрэг, хариуцлага:

Сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн хүлээх үүргийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-т “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй”, 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

этгээдээр дүгнэлт гаргуулан төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасан бол Төрийн аудитын байгууллагын хүлээх үүргийг хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх” гэж заасан.

Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Батсүрэн хэрэгжүүлэн, аудитыг Ахлах аудитор Х.Сувдмаа, аудитор Г.Батмягмар, Э.Одгэрэл, нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Дархан-Уул аймгийн Сонгуулийн хороонд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцохоор аймгийн 21 дүгээр тойрог болон Шарын гол сумын 1, 2 дугаар тойрогт МАН, АН-ны 6 нэр дэвшигчдийг бүртгэж, үнэмлэх олгосон байна.

Сонгуульд оролцсон 2 намын 6 нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлснийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн дансны мэдээлэл

№	Сонгуулийн тойрог	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог нэр	Данс нээлгэсэн эсэх	
				Банкны нэр	Дансны дугаар
1	Шарын гол сумын 1-р тойрог	Ардчилсан нам	Батзаяагийн Эрдэнэбаяр	ХААН	5047606602
2	Аймгийн 21-р тойрог	МАН	Лүндэгийн Наранбаатар	Голомт	3675113703
3	Шарын гол сумын 2-р тойрог	Ардчилсан нам	Ганхуягийн Ууганбаяр	ХААН	5047606680
4	Аймгийн 21-р тойрог	Ардчилсан нам	Дэмбээгийн Батболд	ХААН	5047606589
5	Шарын гол сумын 1-р тойрог	МАН	Энхбаярын Халиун	Төрийн банк	14050186349
6	Шарын гол сумын 2-р тойрог	МАН	Мишитхан Серкболд	Төрийн банк	141501851254

БҮЛЭГ 1. НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭ ХУУЛИАР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН, БОДИТОЙ ЭХ ҮҮСВЭРЭЭС БҮРДҮҮЛЖЭЭ.

Сонгуульд оролцсон 2 нам сонгуулийн зардлын данс нээгээгүй бөгөөд 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3¹-д заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлсэн.

Төрийн аудитын байгууллагад сонгуульд оролцсон 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3²-д заасан хугацаанд ирүүлж, харин 2 нам сонгуулийн зардлын данс нээгээгүй тул тайлан ирүүлээгүй болно.

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон МАН-ын 3 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд мөнгөн хандиваар 20.7 сая төгрөг, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс 9.9 сая төгрөг, нийт 30.6 сая төгрөг төвлөрсөн байна. Мөнгөн хандиваас хуулиар хүлээн зөвшөөрөөгүй 1 иргэний 10.9 сая төгрөгийн хандивыг буцааснаар нэр дэвшигчид сонгуульд нийт 19.7 сая төгрөг зарцуулжээ. Харин АН-ын 3 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа нийт 1.0 мянган төгрөг төвлөрүүлж, банкны шимтгэлд төлсөн байна. (Хавсралт 1)

Давхардсан тоогоор 6 иргэнээс 9.8 сая төгрөгийн хандив бүрдүүлжээ.

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр

сая/төг

№	Санхүүжилт, эх үүсвэр	Нам, нэр дэвшигчийн тоо	Дүн /сая төгрөг/	Иргэн, хуулийн этгээдийн тоо
1	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	0	0	-
2	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	6	9.9	-
3	Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив	0	0	0
	Үүнээс: Мөнгөн хандив	0	0	0
	Мөнгөн бус хандив	0	0	0
4	Иргэний өгсөн нийт хандив	0	9.8	6
	Үүнээс: Мөнгөн хандив	0	9.8	6
	Мөнгөн бус хандив	0	0	0
	Нийт дүн	6	19.7	6

Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

Сонгуульд оролцсон нэр дэвшигчид Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Дархан-Уул аймаг дахь төрийн аудитын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/26 тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд

¹ 50.3. Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй

² 56.3 Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ

оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу санхүүжилтийг бүрдүүлжээ.

БҮЛЭГ 2. НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛЬД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БАРИМТАЛЖ, ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 2 нам, 6 нэр дэвшигчийн нийт 19.7 сая төгрөгийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлсэн.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлаас үзэхэд сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал 89.3 хувийг, бусад зардал 10.7 хувийг тус тус эзэлж байна. *Хавсралт 2.*

Хүснэгт 3. Сонгуулийн зардлын гүйцэтгэл

№	Зардлын ангилал	Нам, нэр дэвшигчийн тоо	Дүн /сая төгрөг/	Эзлэх хувь
1	Сонгуулийн зардал	271	1,001.4	90.7
1.1	Үүнээс: Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	-	-	-
1.2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	-	-	-
1.3	Намын далбааг гудамж, талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	-	-	-
1.4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	-	-	-
1.5	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	3	17.6	89.3
1.6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	-	-	-
1.7	Цахим орчин ашиглах зардал	-	-	-
1.8	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	-	-	-
2	Бусад зардлын дүн	6	2.1	10.7
	Нийт дүн	9	19.7	100.0

Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

Аудитаар сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдээс ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг Дархан-Уул аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/20, А/21 дүгээр тушаалаар тогтоосон “Дархан-Уул аймаг, сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ”-тэй тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

Нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд аудит хийсэн “ЦЭСБ аудит” ХХК, “Ингүүмэл жаргалант аудит” ХХК-ууд Дархан-Уул аймаг дахь төрийн

аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”- д заасан маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлсэн.

Төрийн аудитын байгууллагаас нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэхэд 4 иргэний 2 нэр дэвшигчид өгсөн нийт 7.5 сая төгрөгийн мөнгөн хандив нэг сая төгрөгөөс давсан тул аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1³-д заасны дагуу audit.mn сайтад байршуулж, нийтэд ил тод мэдээлнэ.

Хавсралт 3.

ДҮГНЭЛТ:

Аудитын хуулийн этгээдийн баталгаажуулж ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд аудитын хуулийн этгээдээр баталгаажуулж ирүүлсэн бөгөөд төвлөрсөн нийт 30.6 сая төгрөгийн эх үүсвэрээс хуулиар зөвшөөрөөгүй 1 иргэний 10.9 сая төгрөгийн хандивыг буцааж, 19.7 сая төгрөгийг сонгуульд зарцуулснаар үлдэгдэлгүй тайлагнасан байна.
2. Нэр дэвшигчид зардлын 89.3 хувийг үйл ажиллагааны зардалд, 10.7 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан бөгөөд Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох А/20 дугаар тушаалаар баталсан зардлын дээд хэмжээнээс хэтрүүлээгүй байна.,

3 57.1.Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

Төсвөлөг-2

Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалт

№	Сонгуулийн төсөр	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог нэр	Нийт зардлын дүн	Сонгуулийн сурталчилгаа нь материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд талбайн сонгуулийн сурталчилгааг хийх	Намын далбааг гудамж, талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх	Сонгуулийн үйл ажиллагааг гүйцэтгэх, урамшуулалт, тэмдэг, томилолт.	Сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, радио, телевиз	Цахим орчин ашиглах зардал	Сонин сэтгүүлд материал хэвлүүлэх	тегрөгөөр
													Бусад зардал
1	2	Шарын гол сум Монгол ардын нам	М.Серхболд	4,414,000.00					3,969,000.00				445,000.00
2	1	Шарын гол сум Монгол ардын нам	Э.Халиун	5,410,000.00					4,860,000.00				550,000.00
3	21	Шарын гол сум Монгол ардын нам	Л.Нарбаатар	9,900,000.00					8,820,000.00				1,080,000.00
4	1	Шарын гол сум Ардчилсан нам	Б.Эрдэнэбаяр	300.00									300.00
5	21	Шарын гол сум Ардчилсан нам	Д.Батболд	400.00									400.00
6	1	Шарын гол сум Ардчилсан нам	Г.Ууганбаяр	300.00					17,649,000.00				300.00
				19,725,000.00									2,076,000.00

Судалгаа гаргасан: Аудитор

Э.Одгэрэл

Аймаг, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

/төгрөгөөр/

№	Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр	Хандив өгсөн иргэн болон хуулийн этгээдийн нэр	Мөнгөн хандивын дүн	
			Иргэн /Нэг сая төгрөгөөс дээш/	Хуулийн этгээд /Хоёр сая төгрөгөөс дээш/
1	М.Серкболд	Л.Мөнхзаяа	2,000,000.0	
2	М.Серкболд	А.Март	2,000,000.0	
3	Э.Халиун	Э.Шинэчимэг	1,500,000.0	
4	Э.Халиун	Э.Одончимэг	2,000,000.0	
5				
6				
7				
8				
9				
			7,500,000.0	-

Судалгаа гаргасан: Аудитор



Э.Одгэрэл